

АЛБАНЫ НОХОЙН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

ДХИС-ийн магистрант, Б.Отгонбаяр

Хураангуй: Сүүлийн жилүүдэд анхаарал татаж байгаа мөн анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай асуудлын нэг бол эрэлч нохойн сургалтын асуудал юм. Тэсэрч, дэлбэрэх болон харуул хамгаалалтын төрлийн тусгай мэргэжлийн шаталсан чиглэлийн сургалт дутмаг, алдаа дутагдал гаргах зэрэг асуудал тулгарч байна. Иймээс төрөл мэргэжлийн эрэлч нохойн явагдаж байгаа сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх сургалтын нөлөөг нэмэгдүүлэх асуудлыг анхаарч бусад улс орны сургалтын системтэй харьцуулан судлах, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах зорилт тавьсан юм.

Abstract: One of the issues that has attracted attention in recent years and needs attention is the training of rescue dogs. There are problems such as lack of training of dogs in specialized areas such as explosives and guarding, and related mistakes. Therefore, a goal was set to study the feasibility of expanding and intensifying the training activities of professional search dogs and comparing them with other countries' training systems.

Түлхүүр үг: Албаны нохойн сургалт бэлтгэл, Онцгой байдлын байгууллага

Key word: Search dog training and preparation, Emergency Management Agency.

Удиртгал

Эрт дээр үеэс нохойнууд хүмүүстэй хамтран ажиллаж, нөхөрлөлөөс гадна олон тооны ажлыг хамтдаа хийж ажилласаар ирсэн билээ. Нохойнууд нь хоньчиноор болон малын манаач, хууль сахиулагч, туслах эмч, зарим нь ан агнахад тусалдаг, мөн түүнчлэн дайн байлдаанд доторхой үүрэг гүйцэтгэж байсаар ирсэн хүний үнэнч андын нэг билээ. Гэсэн хэдий ч уламжлал ёсоор амьтдыг сургах, дадлагажуулах шинжлэх ухаан өнөөг хүртэл хөгжиж ирсэн билээ. Хүн төрөлхтний хамгийн сайн найз бол нохой гэдгийг хүн бүр мэддэг.

Өнөө үед та нохойд амьдрах боломж олгож, нохойг зөв сургаж, зөвөөр ашиглах нь зүйтэй байх гэж би боддог.

Албаны нохойг сургах аргыг шинжлэх ухааны И.П.Павловын дээд мэдрэлийн үйл ажиллагааны төрлүүдийн онолын үндэст суурилан Зөвлөлт Холбоот Улсын Биологийн ухааны доктор Л.В Крушинский, ХАА-н шинжлэх ухааны дэд доктор Б.К Меркурьева, Мал эмнэлэгийн шинжлэх ухааны зэрэг горилогч И.Е Изрелевич болон малын эмч: С.А.Ильинский, Н.М Иньков, К.С Стогов, М.И Ваничев, А.П Мазовер, А.П Орлов, В.В Рылов, Н.А Сахаров нар албаны нохой бэлтгэх онолыг боловсруулж бэлтгэн ХАА-н шинжлэх ухааны доктор Зубко В.Н. “Служебная собака” номыг 1952 онд анх хэвлэн гаргаж байжээ. Тус номыг 1983 онд шинэчлэн дахин хэвлэсэн нь өдгөө 2023 он хүртэл Монгол Улсад албаны нохойн сургалтад ашиглаж байна. Мөн дэлхийн бүх оронд уг онолыг ашиглан албанд нохой бэлтгэх тус онолыг суурьлан дараа дараагийн нохой сургах онолыг боловсруулан ажиллаж байна.

И.П.Павловын дээд мэдрэлийн үйл ажиллагааны онолоор нохойг сургах үндсэн 4 арга байна. Үүнд дүрслэн дууриах, хоолоор урамшуулах, механик, холбоот арга буюу хоолны урамшуулах аргыг механик аргатай хослуулан хэрэглэх аргыг боловсруулсан байдаг.

Үндсэн хэсэг

Онцгой байдлын нэр томьёо, үндсэн ухагдахуунууд:

Онцгой байдлын албаны үндсэн нэр томъёо, ойлголт ухагдахуунуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

“Албаны нохойг бэлтгэх” Онцгой байдлын анги, байгууллагад албаны зохих шалгуур хангасан нохойг шалгаруулан авч эрэн хайх, аврах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл олж илрүүлэх, харуул хамгаалалт зэрэг бусад төрөл мэргэжлээр сургах, аврагч-нохой хөтлөгчийг бэлтгэх үйл ажиллагааг;

“Албаны нохой бэлтгэх” гэж тусгайлан сонгогдсон нохойг газар нутгийн цаг уур болон тухайн орчинд дасган олон төрлөөр өөр өөр аргаар сургахыг хэлнэ.

“Аврагч-нохой хөтлөгч” Эрэн хайх, аврах, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл олж илрүүлэх, объектын харуул хамгаалалтад албаны нохойг ашиглан ажиллаж буй мэргэшсэн алба хаагчийг;

“Аврагч-нохой хөтлөгч” гэдэг нь сонгогдсон нохойг өөрийн арга барил, мэргэжлийн ур чадвар, чадамжаа дайчлан сургаж, гамшиг, аюул тохиолдсон үед бэлтгэгдсэн нохойг удирдах мэргэшсэн алба хаагчийг хэлнэ.

“Албаны нохойг ашиглах” Эрэн хайх, аврах, тэсэрч дэлбэрэх бодис олж илрүүлэх, объектын харуул хамгаалалт зэрэг төрөл мэргэжлийн албаны нохой ашиглахыг;

“Албаны нохойг хамгаалах” Албаны нохойг тээвэрлэх, үүрэг гүйцэтгэх, сургалт, дадлагын үед аюулгүй байдлыг нь хангах, бусад үед амраах, арчлах, маллах, тэжээх, эмчлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эмчилгээ сувилгаа хийх үйл ажиллагааг;

Нохой сургагч нь ямар ч нөхцөлд нохойг тээвэрлэлтэд авч явахаар дасгах мөн нохой хөтлөгч нь урьдчилан сэргийлэх анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх шаардлагатай.

“Албаны нохой” Албаны төрөл мэргэжлийн сургалтад хамрагдан шалгалтад тэнцэж, “Батламж” олгогдон албанд ашиглаж буй нохойг;

“Дасгалжуулагч багш” Албаны нохой, түүнийг сургах хөтлөгчийг сургаж, бэлтгэх, онолын болон дадлагын хичээл, давтан сургалтыг биечлэн удирдан ажиллаж буй алба хаагчийг;¹²³

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй.

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй.¹²⁴

Аврагч-нохой хөтлөгч нь:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

¹²³ ОБЕГ-ын даргын 2018 оны А/58 тушаал ,

¹²⁴ ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал

1. Нохойг сургах үндсэн арга зүй

Дасгал сургалт нь сургагчийн команд ба дохио зангалтаар нохойд тогтвортой дадал (нарийн нөхцөлт дадал) суулгахад чиглэгдэнэ. Нөхцөлт дадал нь дээд мэдрэлийн ажиллагааны үндсэн хэлбэр. Бие махбодийн гадаад, дотоод цочруулагчийн үйлдлийн улмаас төв мэдрэлийн тогтолцооны дээд хэсэгт үүссэн түр зуурын холбоогоор дамжин нөхцөлт дадал үүснэ. Нөхцөлт дадал гэдэг нь нөхцөлт цочруулагч болон нөхцөлт бус дадлыг хооронд түр зуур холбоо тогтсоны үндсэн дээр амьдралын явцад, эсвэл тусгай сургалтын үр дүнд үүсдэг бодгалийн дасан зохицох урвал юм. Нохойн мэдрэлийн дээд үйл ажиллагааны үндсийг мэдсэнээр сургагч нохойд нөлөөлөх арга барицыг чадамгай олж нохойд шаардагдах дадал суулгаж хэрэггүй хариу үйлдлийг саатуулахад тус дөхөм болох нөхцөлийг тохируулан сонгож авдаг. Нохойг сургах арга нь сургаж байгаа нохойд сургагч дадал суулгахаар хэрэглэж байгаа арга зүй ба техник юм.

Нохойг сургах аргыг 4 хуваан авч үздэг. Үүнд:

- Нохойг дүрслэн дуурайх аргаар сургах
- Нохойг хоолны урамшуулах аргаар сургах
- Нохойг холбоот аргаар сургах
- Нохойг сургах механик арга

1. Нохойг дүрслэн дуурайх аргаар сургах

Нохойг дүрслэн дуурайх аргаар сургах гэдэг нь сайн сургалт авсан нохойг шинээр сургаж байгаа буюу гөлгөн нохойг дагуулан дүрслэн дуурайлган хийлгэж сургах аргыг илэрхийлж байгаа юм.

2. Нохойг хоолны урамшуулах аргаар сургах

Нохойг шинээр сургаж байгаа үед тодорхой хөдөлгөөн хийхэд сургаж болно. Нохойг өөр дээр дуудах, байранд нь буцаах, саад давуулж сургах, юм эрж олуулах, мөр мөрдүүлж сургах зэрэг дасгал сургууль нохойд олгоход хэрэглэдэг.

3. Нохойг холбоот аргаар сургах

Холбоот арга нь сургалтанд хамгийн сайн үр дүнтэй байдаг. Зохих үйлдэл биелүүлэхэд хоолоор батжуулдаг ба биелүүлээгүй тохиолдолд механик аргаар /өвдөлт/ нөлөөлөл үзүүлнэ. Механик ба хоолны урамшууллын хүчээр зөв хооллох явдал маш чухал. Холбоот аргын давуу тал нь сургагчийн команд ба дохио зангалтад сургахад түргэн болгож, сайн батаждаг ба сургагч, нохой хоёрын хоорондын холбоо итгэлтэй сайн бэхэждэг. Нохой орчны янз бүрийн нөхцөлд найдвартай ажиллаж, зохих хэрэгцээтэй үйлдлийг идэвхтэй хийдэг.

4. Нохойг сургах механик арга

Хэрэв механик нөлөөллийг сургагч нохойд үзүүлж (хавчих, шахах, татах, түлхэх, ташуурдах, шилбүүрдэх г.м.) байгаа бол нохойд голдуу идэвхгүй хамгаалах хариу үйлдэл илэрнэ. Механик нөлөө нь нохойг эзэндээ итгэхгүй болгож сургагч, нохой хоёрын холбоог алдагдуулан нохой ноомой, идэвхгүй, аймхай болгодог нь шаардагдах дадал суулгах ажилд багагүй бэрхшээл учруулах юм уу, эсвэл уг сургалтыг явуулах боломжгүй болгодог. Механик аргыг болж өгвөл аль болох бага хэрэглэх шаардлагатай.

Албанд нохой бэлтгэх

Албанд нохой бэлтгэхэд үндсэн 3 үе шаттай байна. Нохой сургалт нь ерөнхий дасгал, хэрэглэлтэй дасгал, мэргэжлийн дасгал орно. Мэргэжлийн дасгал нь нохойн ажиллах чиг үүргээс хамааран өөр өөр байх бөгөөд эрлийн албанд, харуул хамгаалалт, нийгмийн бусад салбарт нохойг бэлтгэх сургалт болдог.

Нохойг сургахад сургагчийн үйлдэл чухал бөгөөд дараах үйлдлүүдийг түгээмэл хэргэлдэг. Үүнд:

- Команд- нохойд гадна цочруулагч өгч буй хүний дуу хоолой;
- Дохио зангаа- нохойд гадна цочруулагч өгч буй хүний гар болон биеийн хөдөлгөөн зэрэг болно.

1. Ерөнхий дасгал

Сургагч нь сургалт, дасгалын үед нохойн биеийн зан төлөвийг зохицуулагч гол хүчин зүйл нь байдаг ба албан ажилд ашиглах хэвшлийг бий болгох үйлдлийг биелүүлдэг болгон сургана. Албаны нохойн сургалт нь ерөнхий сургалт ба тусгай сургалт гэсэн хоёр хэсгээс тогтоно. Дасгал сургалт нь нохойд ерөнхий дадал тогтоож эхлээд, улмаар зүй ёсоор ерөнхий ба тусгай дадлыг тогтоохтой зэрэгцэн явагдана. Сургагчийн дасгал сургалтын ажлын амжилт нь түүний онолын мэдлэг ажлын туршлагаас хамаардаг. Ерөнхий сургалтын явцад нохойг тусгай албанд цаашид бэлтгэх үндсэн суурь тавигдаж, ерөнхий дуулгавартай зан байдлын төлөв тогтоож сургагч, нохой хоёрын харилцаа боловсронгуй болж ирдэг. Нохойн гүйцэтгэж байгаа үйлдлийг сайтар хянаж чаддаг байхын тулд хийж байгаа дасгал, сургалтыг цэгцтэй дараалалтай гүйцэтгэж байх хэрэгтэй. Дасгал сургалтын үйл ажиллагааг төлөвлөхдөө өмнө нь хэрэглэж байсан арга барилыг үндэс болгож, зайлшгүй хэрэгцээтэй арга техникийг ашиглах хэрэгтэй. Сургагч нь нохойг командаар, дохио зангалтаар, оосроор удирдах дадалтай болж, мөн сургаж байгаа нохойн зан байдлын онцлогийг судална.

Нохойг хэрэглэлтэй дасгалд сургах

Сургагч нохойг төрөл бүрийн саадыг давуулж сургах нь газар орныг нэгжих, мөрний үнэрээр мөрдүүлэх үед байгалийн янз бүрийн саадыг төвөггүй даван туулдаг болгох зорилготой бөгөөд уг сургалтыг явуулсанаар албан үүргээ гүйцэтгэхэд суурь болдог.

Сургагч нохойг төрөл бүрийн саадыг давуулж сургах нь нохойн бие бялдрын хөгжилтөд сайн нөлөө үзүүлэн нохойг шаламгай, зоригтой, хөдөлгөөний эвсэлтэй болгодог. Энэ дасгал сургалтын гөлгөн байх үеэс эхлэн сургах хэрэгтэй.

Нохойгоор саадыг давуулж сургах дасгал сургалтыг хийхийн тулд Над дээр, Суу, Апорт зэрэг командуудад нөхцөлт дадал тогтоосны дараа эхэлнэ. Нохойг самбар, хашаа, янз бүрийн саадыг давуулж сургахын тулд *хоолны, холбоот, дүрслэн дуурайх* аргуудыг сонгон авч хэрэглэж болно. Дасгал сургалтыг сургагч нохойн бие бялдрын онцлогоос хамаарч хамгийн амархан хөнгөн дасгалаас нь эхлэн хийж гүйцэтгэнэ. Саадыг давуулж сургах дасгал сургалтын эхлэх үед нохойг төрөл бүрийн саадуудын дэргэдүүр зугаалуулан танилцуулж, дасгах хэрэгтэй. Сургагч нохойн хамт 5-6 метрийн зайд богино хөтлөгч оосроор хөтлөн, зүүн талдаа авч зогсоно. Сургагч анхны дасгалыг хийдээ 60-70 см өндөртэй саадыг давуулж сургана. Сургагч нохойтойгоо хамтдаа Зэрэгц гэж команд өгч саад руу гүйхдээ сааднаас 1 м зайд очоод Урагшаа гэж командыг чанга дуугаар өгч саад дээгүүр нохойтой хамт харайна. Сургагч нохойтойгоо саадыг хамтдаа харайсны дараа Сайн гэж урамшуулан илж амтат хүнсний зүйл өгч урамшуулна. Энэ дасгал сургалтыг хэд хэдэн удаа хийсний дараагаар сургагч өөрөө зөвхөн саад хүртэл нохойтойгоо хамт дагуулан гүйж очоод саадаас 1 м орчим зайтай байхад чанга дуугаар Урагшаа гэж команд өгч саад дээгүүр нохойг харайлгаж өөрөө саадын нөгөө талд хурдан тойрч гараад нохойгоо Сайн гэж илж урамшуулан амтат хүнсний зүйл өгнө. Энэ дасгал сургалтыг хэд хэдэн удаа хийсний дараа урт хөтөлгөө оосроор оосорлож, саадаас 2-3 м зайтай нохойг суулгаад оосрын сул үзүүрийг саад дээгүүр давуулж сургагч нөгөө талд нь очиж оосроос татан нохойд Над дээр гэж командаар дуудна. Сургагч нохойг харайх үед Урагшаа гэж команд өгөөд нохойг харайсны

дараа Сайн гэж илж урамшуулж амтат хүнсний зүйл өгч, зугаалуулна. Саад дээгүүр харайж сурсан нохойг сургагч нохойдоо харуулж тэдний хойноос харайлгаж сургах гэж байгаа нохойтойгоо хамт сургагч хойноос нь гүйнэ.

Нохой саадыг бусад нохойн адил дүрслэн дуурайх аргаар харайж чадаж байвал нохойг Сайн гэж илж урамшуулан амтат хүнсний зүйл өгч зугаалуулах буюу дараагийн дасгал сургалтад бэлтгэнэ. Мөн апортод дуртай сайн сурсан нохойг бага зэрэг апортоор нь хөгжөөж байгаад апортыг саад давуулан цаад тал руу нь шиднэ. Нохой апортны араас явах гэж тэмүүлэх үед нь сургагч хамт гүйж саадаас 1 метрийн зайд очсон үед Урагшаа гэж команд дохио зангалтаар саадыг давуулна. Саадын өндрийг нэмэхийн хирээр нохойг оосоргүй харайлгах дасгалжуултад шилжүүлэх хэрэгтэй. Сургагчийн анхны команд, дохио зангалтаар нохой 1-1,5 метрээс өндөргүй, янз бүрийн саадыг давж чаддаг болсон байвал сурсан гэж үздэг. Энэ дасгалыг өдөрт 3-4 удаа тогтмол хийлгэж байх шаардлагатай.

Нохой нь Урагшаа гэж команд ба дохио зангалтаар бие дааж зоригтойгоор төрөл бүрийн саад дээгүүр идэвхтэй харайж байвал сургалтын нөхцөлийг бага зэрэг хүндрүүлнэ. Харайлгах саадын өндрийг сургагч нохойд мэдэгдэлгүй нэмж байх хэрэгтэй. Сургагч нь саадны өндрийг нохойн бие, бялдарт тохируулан 10-15см нэмж, дасгал сургалтыг хийж байх ёстой. Саадын өндрийг нэмэхийн зэрэгцээ оосоргүй сургах дасгал сургалтад шилжин орох ба өндөр саад дээгүүр харайх үед оосор нохойн хөлд орооцолдож өвтгөн улмаар сааталд оруулж болзошгүй. Иймд өндрийг нэмсэн саад дээгүүр харайлгахдаа урт оосрыг урьдчилан давуулан аль болох нохойд саад учруулахгүй арга хэмжээг авч байх хэрэгтэй. Сургагч нохойг 3-4 метр ойр зайнаас хурд хүч авхуулахгүй харайлгавал саадан дээгүүр нохой давж чадахгүйд хүрэх тул саадын өндрөөс халширч, харайхаас татгалздаг.

Сургагч хүний анхаарах нэг гол зүйл бол нохой саадыг амжилттай харайсан бүх тохиолдолд цаг тухайд нь түүнийг урамшуулан илж, зугаалуулж байх хэрэгтэй. Нохой сургагчийн өгсөн анхны команд ба дохио зангалтаар өндрийг нэмсэн саадан дээгүүр харайж өгөхгүй, айсан байдал анзаарагдвал түүнд харайхад нь туслах хэрэгтэй. Нохойг саад дээгүүр дутуу харайх үед нь сургагч түүнийг дороос нь унагалгүй түшин тулж, саврыг нь саадны эхний банзны дээд ирмэгт хүрч байхаар дэмжин өргөж, туслах ёстой. Саадны өндөр нохойг айлгаж байгаа бол саадны өндрийг хасаж, нам болгоно.

Сургагч нохойн биеийн байдлыг сайн ажиглан шинжиж, өмнөх хийсэн дасгал сургалтад ядарсан, бие нь зовуурьтай шинж тэмдэг илэрвэл саад давуулах дасгал сургалтыг шууд зогсоож амрах ёстой. Саадыг дуулгавартай харайлгаж сургахдаа харайхын өмнө тэвчээртэй сууж, сургагчийг хүлээдэг дадлыг нохойд хэвшүүлсэн байх ёстой. Энэ дасгал сургалтыг хийхийн тулд сургагч нохойг сааднаас 3-4 метрийн зайд суулгаад урд нь нэг алхам зайд өөрөө зогсоод Суу гэж команд өгч 10-15 секунд тэвчээртэй суулгана.

Нохойг тэвчээртэй суусны дараа сургагч команд ба дохио зангалтаар саад дээгүүр давуулахаар явуулна. Хэрэв нохой сургагчийн команд ба дохио зангалтгүй саад руу ухасхийх гэж оролдлого хийх үед нь угзран Суу гэж команд давтан өгнө. Нохойг саадан дээгүүр давсаны дараа, сургагч саадыг тойрч гараад нохойд Суу гэж команд өгч суулгаад Сайн гэж урамшуулан амтат хүнсний зүйл өгч илнэ. Сургагч нохойг анхны команд ба дохио зангалтаар 2 метрээс өндөргүй саадуудыг дуулгавартай давж чаддаг болсон үед дадал тогтсон гэж үздэг. Сургагч нохойг төрөл бүрийн саадыг давуулж сургах нь газар орныг нэгжих, мөрний үнэрээр мөрдүүлэх үед байгалийн янз бүрийн саадыг төвөггүй даван туулдаг болж сурсан байна.

Нохойг мэргэжлийн дасгалд сургах арга

Албаны нохойн тусгай сургалт нь эрлийн, харуулын, манааны, хуяглан харгалзах болон бусад албаны үед хэрэглэх боломжтой дадлуудыг нохойд тогтоох зорилготой. Тусгай сургалтад нохойг дараах чиглэлд дасгалжуулан сургаж ашигладаг. Үүнд:

Эрлийн албанд:

- Мөрдлөгт ашиглах;
- Газар, орон, байр, сууц, ой мод, хээр тал, гол, мөрөн, нуур, цөөрөм зэрэгт самнан нэгжих үйл ажиллагаанд ашиглах;
- Мансууруулах бодис, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх эд зүйл эрүүлэх;(хайлгах)
- Нурсан байгууламж болон нурангин дороос хүн ба цогцос хайх;
- Лабораторийн нөхцөлд сонгогдсон үнэрийг таниулах.

Харуул хамгаалалт, манаа, нийгмийн бусад салбарт:

- Харуул хамгаалалт, улсын тусгай хамгаалалтай газрууд;
- Барилга, байгууламж, улсын тусгай хамгаалалтай газрууд, уул уурхай, үйлдвэр, хашаа, агуулах зэргийн харуул хамгаалалтад ашиглах;
- Мал хариулах, хашаа, хороогоо манахад ашиглах;
- Хөллөгөөний болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай сургалт зэрэг болно.

Эд зүйлийг сонгон олоход сургах

Энэ дасгал сургалт нь нохойн үнэрлэх эрхтнийг дасгалжуулж, ялгах дадлыг нь боловсронгуй болгон хэргийн газрын мөрөн дээр үлдээсэн ба эд зүйлийнх нь үнэрээр хүний үнэртэй харьцуулан сонгон олох дадлыг нохойд бий болгоход оршино. Энэхүү дадлыг сургахад нөхцөлт болон нөхцөлт бус цочруулагч гэсэн ухагдахууныг ашигладаг.

Нөхцөлт цочруулагч нь Үнэрт команд ба хэвтэж байгаа эд зүйлийн зүгт баруун гараараа заах дохио зангалт болно. Туслах чанарын цочруулагч нь Орхи, Апорт, Сайн зэрэг командууд байна. Харин нөхцөлт бус цочруулагч нь апорт, эд зүйл болон амтат хүнсний зүйл болно.

Нохойн эд зүйл авчрах нөхцөлт дадал дээр тулгуурлан эд зүйл сонгон олох дадлыг түүнд тогтоодог. Эд зүйл сонгон олох нь нэлээн хүндрүүлсэн нөхцөлтэй апортын үргэлжлэл болох учраас Апорт түүний дотор тусгай бэлтгэл дасгалуудыг маш сайн хийж сурсны дараа сонгон олох үйл ажиллагаанд шилжин ордог.

Нохойг эд зүйлийн үнэрийг өөр хооронд нь харьцуулан ялган таньдаг болгож сургахын тулд янзын бүрийн хэлбэр дүрстэй, төрөл бүрийн хувийн үнэртэй, хатуу, зөөлөн биетэй эд зүйлээр хийсэн төрөл бүрийн апорт эд зүйлийг бэлтгэх хэрэгтэй бөгөөд тэдгээрийг тусгай хайрцаг, уутанд хийж авч явна. Энэ дасгал сургалтад 6-10 хүнтэй сургагч нарын бүлэг оролцох ба тэд нохойг эд зүйлийн үнэрийг өөр хооронд нь харьцуулан ялгаж таньдаг болгон сургана.

Тусгайлан бэлтгэсэн хайрцагт апортлох эд зүйлийн бүрэн хэрэглэл, хямсаа зэргийг байлгана. Нохойг эд зүйлийн үнэрийг өөр хооронд нь харьцуулан ялган таньдаг болгож сургахын тулд хайрцагт хийж хадгалан авч явах апортлох эд зүйлд бусад хүний хувийн үнэр шингээгүй-цэвэрхэн байх хэрэгтэй. Апортлох эд зүйлийг гараараа барьж болохгүй зөвхөн хямсаагаар хавчин авч байх ёстой.

Хүнийг мөрний үнэрээр эрэн хайх

Мөрний үнэрт нохойг сургах нь эрэл, манаа, хуяглан хүргэх албаны нохдын сургалтын үндэс болдог. Энэ нь хүний үлдээсэн мөрний үнэрээр нь эрж олох зорилготой

байдаг. Албаны нохой нь эхлэх цэгээс гарч мөрийг бие даан илрүүлэх, тухайн хүний явсан зүг чигийг тодорхойлох, замдаа нуусан, хаясан эд зүйлийг зөв олж илрүүлэх ёстой.

Нохойд “Мөрд” гэсэн үндсэн командыг өгнө. Эрлийн үед нохойн идэвхийг бууруулахгүйн тулд “үнэрт”, “эрээд”, “сайн” зэрэг командуудыг өгнө.

Мөрдөх дасгал сургалтыг нохойн төрөлхийн инстинкт(зөн совин, тавилан) болох ан гөрөө хийх эрмэлзэлд үндэслэн хүнийг мөрдөн хөөх дадлыг бий болгодог. Нохой нь төрөлхийн инстинкт болох идэвхтэй хамгаалах, хоолны, тоймлох зэрэгийг ашиглан мөрдөх дасгалыг хөгжүүлж болно. Нохойн уур хорслыг хөгжүүлэх зорилгоор туслах сургагчийг ойрын зайд зугтаалгаж, хөөж барихад сургасны дараа энэ сургалтыг эхэлдэг.

Газар орон ба байр сууцыг самнан нэгжих ажиллагаанд нохойг сургах

Албаны нохдыг ашиглах үйл ажиллагаануудын нэг нь газар орон, байр байшин, төрөл бүрийн тээврийн хэрэгслийг нэгжих ажиллагаанд сургах явдал байдаг. Сургагч нохойг самнан нэгжилтээр хүн ба эд зүйлийг эрж олох дасгал сургалтыг хийлгэхдээ талбайг хөрөөний шүдний хэлбэрээр хэрсэн байдалтай эрэх дадлыг нохойд бий болгох ёстой.

Үндсэн нөхцөлт цочруулагч нь Эр команд ба зохих чиглэл рүү сургагч баруун гараар дохио зангалт байх ба туслах чанарын цочруулагч нь Апорт, Сайн, Өг, Орхи зэрэг командууд байдаг. Нөхцөлт бус цочруулагчид апортын эд зүйл, амтат хүнсний зүйлс, туслах сургагчийг ашигладаг.

Мөр мөрдөх ажиллагааг тусгай сургалтын бусад төрлүүдтэй хослуулах нь

Дасгал сургалтыг янз бүрийн нөхцөлтэй, хүндрүүлсэн байдалд оруулж ажиллахын зэрэгцээ эрэлч нохдыг бэлтгэх ажлын төгсөлийн хэсгийг албаны бодит нөхцөлд ойртуулан тусгай сургалтын бусад төрлүүдтэй хослуулан явуулах хэрэгтэй. Жишээ нь: Нохойн уур хорслыг хөгжүүлэх, зугтсан туслах сургагчийг хөөж барих, газар орон самнан нэгжүүлэх, туслах сургагчийн үнэртэй мөр мөрдөх дасгал сургалтууд байна.

Нохойг эрэлд болон харуул хамгаалалтад сургах дасгал сургалтыг хослуулсан сургалт гэнэ. Хослуулсан сургалтыг дэс дараатайгаар явуулах ба дасгалжуулагч багш нь сургагч, туслах сургагч нарт тус тусд нь заавар өгнө. Зааварын дагуу туслах сургагч дасгал сургалт хийх зориулалтын талбай дээр эд зүйл тараан байрлуулаад талбайн төгсгөлөөс эхлэн мөр мөрдүүлэх эхлэх цэг үүсгэж мөрийг гаргана. Сургагч нохойгоо сайн зугаалуулан дотоод сааталгүй болсон үед сургалтын талбайд очно.

Мөрний үнэрийг 30 минут хүртлэх хугацаанд халуун, 3 болон түүнээс дээш цаг болсон тохиолдолд хуучралттай үнэр гэж үздэг. Нохойг эд зүйл самнан нэгжих ажиллагаанд ашиглан эд зүйлийг олуулаад цааш үргэлжлүүлэн мөрдүүлж туслах сургагчийг бариулснаар дасгал сургалт дуусгана. Дараагийн дасгал сургалт нь дасгалжуулагч багш нь сургагч, туслах сургагч нарт тус, тусад нь заавар өгснөөр эхэлнэ. Туслах сургагч зааврын дагуу мөрний эхлэх цэг үүсгэн, 500- метрээс 1 км урттай мөр гарган явж мөрний төгсгөлийн цэгт сургагч нь самнан нэгжилт хийх талбайд эд зүйлийг тарааж хаяна.

Сургагч нохойгоо сайн зугаалуулан дотоод сааталгүй болсон үед сургалтын талбайд очно. Сургагч цаг харж байгаад мөрний шаардагдах хуучралттай болох үед нь сургагч нохойг урт хөтөлгөө оосортойгоор туслах сургагчийн үнэртэй мөрөөр мөрдүүлэн явж, мөрний төгсгөлд нохойг 5-10 минут түр амраасны дараа туслах сургагчийн самнан нэгжилт хийх талбайд тарааж хаясан эд зүйлийг эрүүлж олуулснаар дасгал сургалтаа дуусгана. Дараагийн дасгал сургалт нь дасгалжуулагч багш нь мөн сургагч, туслах сургагч нарт тус тусад нь заавар өгнө. Туслах сургагч, зааврын дагуу мөрний эхлэх цэг үүсгэн 500- метрээс

1 км урттай мөр гарган явж, мөрний төгсгөлийн цэгт туслах сургагч нь орон байранд самнан нэгжилт хийх байранд орж нуугдана.

Сургагч нохойгоо сайн зугаалуулан дотоод сааталгүй болсон үед сургалтын талбайд очно. Сургагч цаг харж байгаад мөрний үнэрийг хуучралттай болох үед нь нохойг урт хөтөлгөө оосортойгоор туслах сургагчийн үнэртэй мөрөөр мөрдүүлэн явж, мөрний төгсгөлд нохойг 5-10 минут түр амраасны дараа орон байр самнан нэгжилт хийх байранд нуугдаж байгаа туслах сургагчийг эрж олуулна. Энэ дасгалыг үргэлжлүүлэн орон байр самнан нэгжих, манаа манах дасгал сургалттай хослуулан сургах дасгалруу шилжүүлж оруулна.

Нохойг манааны албанд сургах

Үүрэг гүйцэтгэж буй манааны пост дээрээ гаднын хүн ойрхон ирсэн байгааг нохой сургагчид чимээгүй мэдэгддэг болгож сургах ба сургагчийн анхны команд дохиогоор зугтааж байгаа туслах сургагчийг барьж авахад сургана.

Нөхцөлт үндсэн цочруулагч нь Сонс гэсэн команд ба туслах сургагчийн зүгт сургагч баруун гараа сунган заах зангалт байна. Туслах чанарын цочруулагч нь Орхи, Сайн гэх зэрэг командууд болно. Нөхцөлт бус цочруулагч нь туслах сургагчийн нохойг саваа буюу ташуураар хөнгөн цохих цохилт болно.

Нохойг отож хүлээхэд сургах дасгал сургалт нь баримжаалах, хамгаалах хариу үйлдэлтэй нягт холбоотой байдаг ба нохойн сэрэмжлэх төрөлхийн инстинктийг ашиглах үндсэн дээр тулгуурлан хэрэглэнэ. Ингэхдээ манааны нохойг сургах дасгал сургалт хийж сургасны дараа нохойг отож хүлээхэд сургана.

Харуул хамгаалалтын нохой бэлтгэх

Харуул хамгаалалтын нохойг бэлтгэж ашиглах нь цэргийн болон энгийн төрөл бүрийн объектуудын харуул, хамгаалалтыг хүч нэмэгдүүлж, хамгаалалтад байх хүмүүсийн тоог хорогдуулах нөхцөл боломжийг гаргадаг. Харуулын нохойг гаднын хүмүүс хамгаалж байгаа объектод ойртон ирэх үед хүчтэй чанга хуцдаг, нэвтрэх гэж оролдсон хүмүүсийг хөөж барих, нэвтэрсэн гаднын хүнийг самнан нэгжилтээр олж, илрүүлэхэд сургасан байна.

Нөхцөлт цочруулагч нь Хамгаал команд ба дохио зангалт нь сургагч баруун гараараа туслах сургагчийн зүг заах. Туслах чанарын цочруулагч нь Орхи, Сайн гэх зэрэг команд. Нөхцөлт бус цочруулагч нь туслах сургагч нохойг саваа ба ташуураар хөнгөн цохих болно.

Харуул, хамгаалалтын нохойг сургах дасгал сургалт нь нохой дуулгавартай байх, уур хорслыг хөгжүүлэх анхны нөхцөлт дадал тогтоож, зугтааж байгаа туслах сургагчийг хөөж бариулж сургасны дараа энэ дасгал сургалтыг эхэлнэ.

Хууль сахиулах, Онцгой байдлын албаны нохойн сургалтын гадаад орны туршлага

1954 оноос ОХУ, АНУ, Герман, Швейцар, улсууд Онцгой байдлын албанд эрлийн аврах нохдыг бэлтгэх сургалтын төвүүд бий болж эхэлсэн байна.

1972 онд олон улсын эрэн хайх аврах нохойн байгууллага нь Австри Улсын Салцбург хотод байгуулагдсан бөгөөд одоо 39 орны 115 гишүүн байгууллагаас бүрддэг байна. Үүнд: Австри, Канад, Аргентин, Бельги, Бразил, Чили, Колумб, Кroatия, Бүгд найрамдах Чех улс, Дани, Эстон, Финлянд, Нидерланд, Швейцар, Тайланд, Турк, Франц, Герман, Унгар, Итали, Япон, Өмнөд Солонгос, Мексик, Норвеги, Польш, Румын, ОХУ, Словени, Словака, Испани, Швед, АНУ, Тайвань, Арабын Нэгдсэн улс, Урагвай, Өмнөд Америк зэрэг орон байдаг.¹²⁵

Хууль сахиулах, Онцгой байдлын салбарт дараах үлдэрийн нохдыг түгээмэл ашиглаж байна. Үүнд: эрдель терьер, акита, малиноис, берн уулын нохой, блүүдхаунд,

¹²⁵ НҮБ-ын дэргэдэх Олон улсын аврагч нохой байгууллага Цахим эх сурвалж холбоос <http://www.insarag.org/en/iec.html>

бордер колли, боксер, хорват хоньч нохой, доберман, герман хоньч нохой, реферд, поинтер, лабрадор, ретривер, ротвейлер, англи спрингер, спаниель үүлдрийн ноход багтдаг.¹²⁶

Албаны нохойг сургах нь нохой тэжээгчийг сургахаас эхэлдэг тул маш урт үйл явц юм. Нохой тэжээгчид нохойг хамгийн сайн сургаж сургахын тулд урт хугацааны сургалтад хамрагддаг. Нэгдүгээрт, нохойн эмч нь цагдаагийн академийн шаардлагатай сургалтад хамрагдаж, нэгээс хоёр жилийн эргүүлийн туршлагатай байх ёстой бөгөөд нохойн мэргэжлийн анги руу шилжих эрхтэй болно.¹⁹ Учир нь офицерын туршлага нь ирээдүйн нохойн ажилтнуудад хууль сахиулах ажилд үнэ цэнтэй туршлага хуримтлуулах боломжийг олгодог. Харин цагдаагийн сургуулиас гадуур нохойн мэдлэгтэй, сургах чадвартай байх нь нохойд дуулгавартай байх, олныг хянах, амьтадтай үр дүнтэй харилцах, ойр дотнын хүмүүсийн анхаарлыг татахуйц нохойтой байх нь чухал ач холбогдолтой гэж үздэг.

Албанд нохойг сонгон авахын тулд эхлээд дуулгавартай байдлын анхан шатны сургалтад хамрагдах ёстой. Тэд удирдагчийнхаа тушаалыг эргэлзэлгүйгээр дагаж мөрдөх чадвартай байх ёстой.¹²⁷ Энэ нь нохой сэжигтний эсрэг хэр их хүч хэрэглэхийг офицерт бүрэн хянах боломжийг олгодог. Европт сургасан нохойд ихэвчлэн тухайн улсын төрөлх хэлээр команд өгдөг. Нохойг энэ хэлээр анхлан зан төлөвт сургадаг тул офицер нохойг шинэ команд сургахаас илүү шинэ үг команд сурахад илүү хялбар байдаг. Энэ нь цагдаагийн нохойг өөр хэлээр сургадаг гэсэн түгээмэл итгэл үнэмшилтэй зөрчилдөж байгаа тул сэжигтэн нохойг офицерын эсрэг команд өгөх боломжгүй юм.¹²⁸

Онцгой байдлын албанд ашигладаг нохойг нэг зорилготой эсвэл давхар зорилготой гэж сургадаг. Нэг зориулалтын нохойг үндсэндээ нөөцлөх, хувийн хамгаалалт, мөрдөхөд ашигладаг. Гэсэн хэдий ч хос зориулалттай ноход илүү түгээмэл байдаг. Хос зориулалтын нохой нь нэг зориулалттай нохойн хийдэг бүх зүйлийг хийхээс гадна тэсрэх бодис, хар тамхи зэргийг илрүүлдэг. Нохой нь тэсэрч дэлбэрэх бодис, хар тамхи илрүүлсэн тохиолдолд алба хаагчтай холбоо тогтоох боломжгүй тул нохойг зөвхөн нэг эсвэл нөгөөд сургах боломжтой. АНУ-д байдаг хар тамхины нохой офицерт ямар нэг зүйл олсон гэж хэлэх үед ихэнх мужид тухайн нохой анхааруулга өгсөн бүх зүйлийг (жишээ нь цүнх эсвэл тээврийн хэрэгсэл) ямар ч зөвшөөрөлгүйгээр хайх боломжтой байдаг.^{22,23}

Энэхүү судалгаандаа дараах 18 орны албаны нохой ашиглалтын талаар судлан авч үзлээ. Үүнд: Австрали, Бангладеш, Бельги, Канад, Дани, Япон, Непал, Швед, АНУ, Хонконг, Нидерланд, Энэтхэг, Израйл, Итали, Кени, Перу, Их британи зэрэг болно.

Дэлхийн олон орны хууль сахиулах Онцгой байдлын албаны нохойг идэвхтэй ашигладаг¹²⁹ төдийгүй сайтар бэлтгэгдсэн албаны нохой нь найдвартай, шуурхай, үр дүнтэй үйл ажилгааны үндэс болдог гэж үздэг¹³⁰.

Бүгд Найрамдах Солонгос Улс

Бүгд Найрмдах Солонгос Улсын Үндэсний аврах 116-р бригадын нохой сургалтын төв нь 2021 оны байдлаар эрэн хайх аврах чиглэлээр 78 нохой бэлтгэн эрэн хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байна. Тус бригад нь сайн дурын 18 клубтэй хамтран албаны нохой сургах, бэлтгэх үйл ажиллагаа явуулдгаараа онцлогтой байна.

Австрали

¹²⁶ Allsopp 2012, p. 14–17.

¹²⁷ "Dogs of all nations Mason, Walter Esplin, 1867–Free Download, Borrow, and Streaming Internet Archive". Internet Archive. 1915

¹²⁸ Grabianowski, Ed (3 May 2004). "How Police Dogs Work". How Stuff Works. Retrieved 10 May 2017.

¹²⁹ J. Ensminger, Development of police and military dog functions, in: (Ed.), Police and Military Dogs, CRC Press, Boca Raton, FL, 2012, pp. 3–17.

¹³⁰ L.P. Waggoner, J.M. Johnston, M. Williams, J. Jackson, M. Jones, T. Boussom, J.A. Petrousky, Canine olfactory sensitivity to cocaine hydrochloride and methyl benzoate, in: Proceedings SPIE 2937, Chemistry- and Biology-Based Technologies for Contraband Detection, 216, 1997, <http://dx.doi.org/10.1117/12.266775>

Австралийн Холбооны Ерөнхий зориулалтын цагдаагийн нохдыг ажиллуулдаг бөгөөд тэдний үүрэг нь сураггүй болсон хүмүүсийг эрэн хайх, сэжигтэй этгээдийг баривчлах, амар тайван байдлыг сахиулах зэрэг болно. Австралийн Холбооны цагдаа мөн галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, хууль бус хар тамхи, валют илрүүлэх зэрэг тусгай зориулалтаар сургасан цагдаагийн нохойг ажиллуулдаг.¹³¹ Австралийн хилийн цэргийн алба мөн хилийн шалган нэвтрүүлэх боомт дээр нуугдаж буй хүмүүс болон хууль бус бүтээгдэхүүнийг хайж олохын тулд илрүүлэгч нохойг ашигладаг.¹³²

Бангладеш

Бангладешийн хилийн цэрэг, Шуурхай ажиллагааны батальон, Дака хотын цагдаагийн газар хар тамхины эсрэг болон бөмбөгдөлттэй тэмцэх компанит ажилд туслах зорилгоор хэд хэдэн нохойн багийг ажиллуулдаг.¹³³

Бельги

Бельгийн нохойг дэмжих бүлэг нь тус Улсын холбооны цагдаагийн нэг хэсэг юм. Энэ нь 35 нохойн багтай бөгөөд ихэнх нь Бельгийн Малиноис юм. Зарим нохойг хар тамхи, хүний үлдэгдэл, гормон, галын хурдасгагч бодис илрүүлэхэд сургадаг. Гуравны нэг орчим нь амьд хүмүүсийг олох, таних зорилгоор сургагдсан мөрдөгч нохой юм. Эдгээр багууд ихэвчлэн нурсан барилгад дарагдсан хүмүүсийн байршлыг тогтоохын тулд газар хөдлөлтийн бүсэд очдог. Холбооны цагдаагийн тэсрэх бодис илрүүлэгч ноход Холбооны цагдаагийн ангиудад байдаг.¹³⁴

Канад

K9 нэгжүүд Онтарио мужийн Иорк мужид сураггүй болсон хүнийг хайх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Канадчууд 1908 оноос цагдаагийн нохойг шаардлагатай үед ашиглаж эхэлсэн. Гэсэн хэдий ч 1935 он хүртэл Канадын хатан хааны морьт цагдаа (RCMP) цагдаагийн нохойн үнэ цэнийг олж харж, 1937 онд анхны багийг байгуулсан.¹³⁵ 1950-иад он гэхэд RCMP герман хоньч ноход, шнаузерууд, доберман пинчерүүд үйлчилж байсан.¹³⁶

ДҮГНЭЛТ

Онцгой байдлын аврагч нохойнууд нь 180 хоногийн хугацаатай сургалтад хамрагдаж “АЛБАНЫ НОХОЙН БАТЛАМЖ”-тай төгсдөг бол Олон Улсын аврагч нохойнууд нь мэргэжлийн гэрчилгээтэй болон офицер нохойнууд их байдаг байна.

Энэ нь аврагч нохойнуудын түвшинг харуулж байгаа ба нөгөө талаасаа гамшиг ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах талаар илүү үр дүнтэй үүрэг гүйцэтгэх баталгаа болж байгаа юм.

Эрэн хайх, аврах, харуул хамгаалалт болон бусад ажиллагаанд ажиллаж буй аврагч нохойнуудын ажлын гүйцэтгэлээс шалтгаалж ажлын эцсийн үр дүн хамаардаг боловч аврагч-нохой хөтлөгчгүйгээр төсөөлөлтгүй билээ.

¹³¹ "Detector Dog Program". Australian Border Force. 6 July 2020. Retrieved 3 June 2022.

¹³² Government of Canada, Royal Canadian Mounted Police (6 July 2004). "Police Dog Services". www.rcmp-grc.gc.ca.

¹³³ Sloane, Charles F. (1955). "Dogs in War, Police Work and on Patrol". *Journal of Criminal Law and Criminology*. **46** (3): 385–395. doi:10.2307/1139438. JSTOR 1139438.

¹³⁴ SitStay. "Police dog training 101". sitstay.com. Retrieved 2 November 2018. Government of Canada, Royal Canadian Mounted Police (6 July 2004). "Police Dog Services". www.rcmp-grc.gc.ca.

¹³⁵ Sloane, Charles F. (1955). "Dogs in War, Police Work and on Patrol". *Journal of Criminal Law and Criminology*. **46** (3): 385–395. doi:10.2307/1139438. JSTOR 1139438.

¹³⁶ "Canadian Evidence Law: K9 Searches". Archived from the original on 8 October 2016. Retrieved 16 June 2016.

¹³⁶ Macrae, Penelope (9 August 2012). "India stray dogs to form security squad". Yahoo!. Retrieved 3 October 2014.

Иймээс байгууллагын шаардлагад нийцсэн чадварлаг боловсон хүчинтэй байх, ажилчдынхаа мэдлэг мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх талаар шат дараалласан сургалтад хамруулах нь зайлшгүй шаардлагатай болж байна.

Зарим Улс орнууд албаны нохойг сургах нь нохой тэжээгчийг сургахаас эхэлдэг тул маш урт үйл явц юм. Нохой тэжээгчид нохойг хамгийн сайн сургаж сургахын тулд урт хугацааны сургалтад хамрагддаг. Нэгдүгээрт, нохойн эмч нь цагдаагийн академийн шаардлагатай сургалтад хамрагдаж, нэгээс хоёр жилийн эргүүлийн туршлагатай байх ёстой бөгөөд нохойн мэргэжлийн анги руу шилжих эрхтэй болно. Учир нь офицерын туршлага нь ирээдүйн нохойн ажилтнуудад хууль сахиулах ажилд үнэ цэнтэй туршлага хуримтлуулах боломжийг олгодог. Харин цагдаагийн сургуулиас гадуур нохойн мэдлэгтэй, сургах чадвартай байх нь нохойд дуулгавартай байх, олныг хянах, амьтадтай үр дүнтэй харилцах, ойр дотнын хүмүүсийн анхаарлыг татахуйц нохойтой байх нь чухал ач холбогдолтой гэж үздэг.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. И.П.Павлов “Служебная собака” 1952 года
2. ОБЕГ-ын даргын 2018 оны А/58 тушаал
3. ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал, Албан тушаалын тодорхойлолт
4. НҮБ-ын дэргэдэх Олон улсын аврагч нохой байгууллага Цахим эх сурвалж холбоос <http://www.insarag.org/en/iec.html>
5. Allsopp 2012, p. 14–17.
6. "Dogs of all nations Mason, Walter Esplin, 1867–Free Download, Borrow, and Streaming Internet Archive".Internet Archive. 1915
7. Grabianowski, Ed (3 May 2004). "How Police Dogs Work". How Stuff Works. Retrieved 10 May 2017
8. J.Ensminger, Development of police and military dog functions, in: (Ed.), Police and Military Dogs, CRC Press, Boca Raton, FL, 2012, pp. 3–17
9. L.P. Waggoner, J.M. Johnston, M. Williams, J. Jackson, M. Jones, T. Boussom, J.A. Petrousky, Canine olfactory sensitivity to cocaine hydrochloride and methyl benzoate, in: Proceedings SPIE 2937, Chemistry- and Biology-Based Technologies for Contraband Detection, 216, 1997, <http://dx.doi.org/10.1117/12.266775>
10. "Detector Dog Program". Australian Border Force. 6 July 2020. Retrieved 3 June 2022.
11. Government of Canada, Royal Canadian Mounted Police (6 July 2004). "Police Dog Services". www.rcmp-grc.gc.ca
12. Sloane, Charles F. (1955). "Dogs in War, Police Work and on Patrol". Journal of Criminal Law and Criminology. 46 (3): 385–395. doi:10.2307/1139438. JSTOR 1139438.
13. SitStay. "Police dog training 101". sitstay.com. Retrieved 2 November 2018. Government of Canada, Royal Canadian Mounted Police (6 July 2004). "Police Dog Services". www.rcmp-grc.gc.ca
14. "Canadian Evidence Law: K9 Searches". Archived from the original on 8 October 2016. Retrieved 16 June 2016
15. Macrae, Penelope (9 August 2012). "India stray dogs to form security squad". Yahoo!. Retrieved 3 October 2014